**ТӨВ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/253 Зуунмод

Зөвлөгөөн зохион байгуулах
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Аймгийн ИТХ-ын Төсөв батлах тухай 03 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага болон төрийн захиргааны байгууллагуудыг оролцуулсан "Хариуцлагатай уул уурхай Нөхөн сэргээлт-Тэрбум мод" орон нутгийн зөвлөгөөнийг 05 дугаар сарын 02-нд зохион байгуулсугай.

2. "Хариуцлагатай уул уурхай Нөхөн сэргээлт-Тэрбум мод" орон нутгийн зөвлөгөөний хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах зардал 11,700,500 (арван нэгэн сая долоон зуун мянга таван зуу) төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХБААТАР

4122010719

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дүгээр сарын 28-ны өдрийн
А/253 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ
УУРХАЙ-НӨХӨН СЭРГЭЭЛТ-ТЭРБУМ МОД”
ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гарын авлага, материал | | | | 795,500 |
| | Мэдээллийн хөлтэй самбар | ширхэг | 4 | 50,000 | 200,000 |
| | Мандат, урилга | ширхэг | 100 | 4000 | 400,000 |
| | Ус | ширхэг | 230 | | 195,500 |
| 2 | Цайны завсарлага | | | | 2.800.000 |
| | Цайны завсарлага | хүн | 140 | 20000 | 2.800.000 |
| 3 | Үдийн хоол | | | | 7,000,000 |
| | Хоол 1,2-р хоол зууш | хүн | 140 | 50000 | 7,000,000 |
| 4 | Бусад зардал | | | | 1,105,000 |
| | Led дэлгэцийн түрээс | цаг | 10 | 100,000 | 1.000.000 |
| | Хулдаасан хэвлэл /3.5*2.5/ | $M^2$ | 8.75 | 12,000 | 105,000 |
| Нийт | | | | | 11,700,500 |